

## **Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай**

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө [OTESIA@ot.mn](mailto:OTESIA@ot.mn) хаягаар ирүүлнэ үү.

## Оюу Толгойн БОННУ: Нэмэлт Санамж бичиг

### Оюу Толгойн төслийн талбайгаас Гашуун Сухайт хүртэлх зам

#### Агуулга

1.1	ТАНИЛЦУУЛГА .....	3
1.2	Төслийн орчин .....	3
1.3	АНХНЫ ТӨЛӨВЛӨСӨН ЗАМЫН МАРШРУТАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ – ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ШИНЭЧЛЭН ӨӨРЧЛӨЛТ .....	4
1.3.1	<i>Чиглэл өөрчлөгдсөн зам</i> .....	4
1.3.2	<i>Шинэчлэгдсэн маршрутын зам</i> .....	5
1.4	Чиглэл өөрчлөгдсөн замын одоогийн байдал .....	8
1.5	Байгаль орчны болон Нийгмийн асуудлууд .....	8
1.6	Байгаль орчин, нийгмийн судалгааны ХАМРАХ ХҮРЭЭ .....	9
1.7	Үнэлгээний АРГАЧЛАЛ .....	10
1.8	Үнэлгээний ТАЙЛАН .....	11
1.9	Үнэлгээний ХИЙХ ХУГАЦАА .....	11

#### Зураг

1-р Зураг: Замын Товчлон өөрчлөлт болон Дахин Өөрчлөлт .....	7
--	---

## 1. Оюу Толгойн төслийн талбайгаас гашуун сухайт хүртэлх зам

### 1.1 ТАНИЛЦУУЛГА

Оюу Толгой төслийн хурдацтай хөгжил нь Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОННБҮ)-нд тусгагдаагүй нэмэлт үнэлгээг хийх шаардлагыг бий болгож байна. Эдгээр нэмэлт үнэлгээг Оюу Толгой төслийн өөрчлөлтийн журмын менежментийн хүрээнд авч үзсэн. Нэмэлтээр хийх шаардлагатай үнэлгээний нэг нь Төслийн хүрээнд ашиглагдах Оюу Толгойн уурхайн талбайгаас Монгол-Хятадын хилийн Гашуун Сухайт хүртэлх замтай холбоотойгоор хийх үнэлгээ юм.

БОННБҮ-ийн *Бүлэг А4 – Төслийн тодорхойлолт*, (Анхны зураг төсөлд тусгагдсан замын маршрутыг харуулсан 1-р зураг ) Оюу Толгой төслийн зүгээс Говийн бага дархан цаазат газрын (ГБДЦГ) дундуур өнгөрөх, хамгаалалтын зэрэглэл хамгийн бага, одоо байгаа замыг ашиглан Гашуун Сухайтын хилийн боомтын, зам ашиглаж болохыг зөвшөөрсөн бүсэд байгаа улсын чанартай замын маршруттай нийлүүлэхийг зорьсон. Төсөл замыг барихдаа анхны маршрутын дагуу цаг агаарын бүх нөхцөл байдалд ашиглаж болох, хайрган суурьтай, машин зорчих хэсгийн өргөн нь 8 метр, замын хоёр талд машин зогсож болох 1 метрийн өргөнтэй талбай байхаар төлөвлөсөн. Энэхүү зам нь зургаан тэнхлэгтэй бөгөөд тэнхлэг тус бүр нь хамгийн ихдээ 10 тонн ачаа даах хүчин чадалтай ,, 40 тонны даацтай трейлер машин болон ачааны машинаар (нийт ачааны дээд хэмжээ 55 тонн) хүдрийн баяжмалыг Хятад улс руу тээвэрлэхэд зориулагдсан юм.

Гэхдээ *Бүлэг 1.2-т* дэлгэрэнгүй заасны дагуу анхны зураг төслийн маршрутын дагуу зам барих зайлшгүй нөхцөл байдал үүссэнтэй уялдан төслийн зүгээс БОННБҮ-д дурдсаны дагуу дараахь хоёр өөрчлөлт хийхээр болсон. Үүнд:

- Монгол улсын Засгийн газар анхны төлөвлөсөн замын хэт ачааллыг шийдэх талаар дэмжлэг, туслалцааг авах хүртэл Анхны төлөвлөсөн замын маршрутыг (Чиглэл өөрчлөгдсөн зам) ашиглахын оронд түр зүүрын чиглэл өөрчлөгдсөн маршрутыг ашиглах ;
- Монгол улсын Засгийн Газраас өгсөн цэргийн баазын нутаг дэвсгэрээс зайлсхийх зөвлөмжийг дагах үүднээс Анхны замын маршрутыг (Дахин өөрчлөгдсөн зам) өөрчлөх шаардлагатай болсон.

Оюу Толгой уурхайн БОННБҮ-ний энэхүү Нэмэлт санамж бичиг нь анхны төлөвлөж байсан дэд бүтцийн бүтээн байгуулалтанд орсон өөрчлөлт болон хувилбарыг тодруулах зорилготой юм. Дээрх хоёр тохиолдолд ГБДЦГ-аар дайрч байгаа болон ойрхон дайрч өнгөрч байгаа зэргээс шалтгаалан замын маршрутын өөр хувилбар нь ихээхэн саад бэрхшээл, хязгаарлалттай тулгарч байгааг харуулж байна.

Энэ бичиг баримтанд Чиглэл өөрчлөгдсөн зам болон Шинэчлэгдсэн замын маршрутын одоогийн нөхцөл байдлыг тодорхойлж байгаа билээ. Чиглэл өөрчлөгдсөн болон Шинэчлэгдсэн замын маршрутын үнэлгээг хийхэд шаардлагатай байгаль орчин болон нийгмийн судалгааны ажлын цар хүрээг үнэлгээний аргачлал болон хийхээр төлөвлөж байгаа хугацааг мөн оруулсан болно.

2012 оны 12-р сард өгөх Нэмэлт үнэлгээгээний тайланд боломжит нөлөөлөл болон эрсдлийн үнэлгээг оруулна.

### 1.2 ТӨСЛИЙН ОРЧИН

Оюу Толгой ХХК болон Монгол улсын Засгийн газар 2007 онд Оюу Толгойн төслийн талбайгаас Гашуун Сухайтын зам хүртэлх замыг сайжруулах болон урт удаан хугацааны менежмент хийхтэй холбоотой Харилцан Ойлголцлолын Санамж Бичигт гарын үсэг зурсан (1-р зурагт үзүүлсэн) анхны төлөвлөсөн замын маршрут. Энэ замыг өмнө нь орон нутгийн тээвэр, худалдааны зориулалтаар болон Монгол-Хятадын Гашуун-Сухайтын хилийн боомтод очих зориулалтаар ашигладаг байсан. Түүнчлэн тус замыг Оюу Толгойн барилгын ажлын явцад Хятад улсаас импортлосон материалыг тээвэрлэхэд мөн ашиглаж байсан. Оюу Толгой ХХК гадаргыг нь тэгшилсэн энэ замын засвар үйлчилгээг хариуцан сайжруулж байсан билээ. 2011 оны 11-р сард Оюу Толгой ХХК нь компанийн болон нийтийн зориулалтаар ашиглахаар Монгол улсын стандартын дагуу хатуу битум гадаргатай зам болгон сайжруулах ажлыг төлөвлөн эхлүүлсэн билээ. Зам баригдаж дууссаны дараа Монгол улсын Засгийн газар замын засвар үйлчилгээний ажлыг хариуцах юм.

Хилийн цэргийн удирдах газар Оюу Толгой-Гашуун Сухайтын замын цэргийн байгууламжтай ойрхон хэсгийг барихыг эсэргүүцсэн бөгөөд энэ хэсгийг цэргийн байгууламжаас холдуулах зорилгоор дахин өөрчлөх шаардлагатай болсон.

2004 оны 5-р сараас хойш нүүрсний компаниуд Таван Толгойн уурхайгаас болон өөр бусад жижиг уурхайгаас Гашуун Сухайтын хилийн боомт руу 1-р зураг дээр одоогийн нүүрсний зам хэмээн заасан шороон замаар тээврийн том машинаар нүүрс тээвэрлэж эхэлсэн. Цагаан Хадын албан бус суурин газарт нүүрсийг овоолж хураах бөгөөд Гашуун Сухайтаас хятадын машинууд ирж Хятадын хил рүү нүүрсийг зөөдөг (зөвхөн Хятадын машинууд хилээр гардаг учраас) байна. Цагаан Хад бол анхны төлөвлөсөн маршрутын зам болон одоогийн нүүрсний замын нийлэх цэг юм. Энэ хоёр зам нь Цагаан Хад болон хилийн хооронд адилхан түвшинд байна. Сайжруулсан анхны төлөвлөсөн замын маршрутыг одоогийн нүүрсний замын маршруттай нийлүүлэхээр төлөвлөсөн байсан.

Энержи Ресурс (ЭР) тэргүүтэй нүүрсний компаниуд Цагаан Хад болон Гашуун Сухайтын хооронд шинэ засмал зам барьж, нүүрсээ хил рүү экспортлох сайн чанарын замтай болсон (1-р зураг дээр үзүүлсэн Энержи Ресурсын засмал зам). Энэ засмал замыг ашиглахад төлбөр төлдөг учраас Хятадын нүүрсний ихэнх машинууд Цагаан Хадны анхны төлөвлөсөн маршрутын замыг төлбөр төлдөггүй тул ашиглах нь олонтоо байдаг. Мөн ЭР-ын засмал замаар явахад даацын хязгаарлалт байдаг тул даац хэтэрсэн нүүрсний машины хэрэглээг хязгаарлаж байдаг.

Анхны төлөвлөсөн замын маршрутын Цагаан Хадаас хил хүртэлх замын хэсэгт Төслийн хувьд замын хэт ачаалал хэвээрээ байгаа бөгөөд Оюу Толгойн хил хүртэлх тээврийн үйл ажиллагааг ихээхэн аюултай, ачаалалтай болгож, анхны төлөвлөсөн маршрутын замын энэ хэсгийн дагуу үйл ажиллагааны зам барих үйл ажиллагаанд саад учруулж байна. Цагаан Хадаас хил хүртэлх анхны төлөвлөсөн замын маршрутын замын нүүрсний машинууд ашигласан хэвээр байгаа тул энэ хэсгийн (дахин шинэчлэх замын хэсэг үүнд орно) барилгын ажил үргэлжлэхэд саад бэрхшээл учирч байна.

Төслийн тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны шийдлийг яаралтай олох шаардлагатай байсан учраас Оюу Толгой түр хугацаагаар Чиглэл өөрчлөгдсөн замыг ашиглаж эхэлсэн.

Оюу толгойн хийсэн замын хөдөлгөөний судалгаагаар (БОННБУ Бүлэг Б11: Тээвэр ба Дэд бүтэц- г үзнэ үү) нүүрс тээвэрлэх замын хөдөлгөөний ачаалал нь өдөрт ойролцоогоор 800 тээврийн хэрэгсэл зорчдог гэж гарсан байна. Эсрэгээрээ, Оюу толгойн тээврийн хэрэгслийн ачаалал нь барилгатай холбоотой тээвэрлэлт буурсан түүнчлэн зэсийн баяжмал экспортлох тээвэрлэлтийн ажил эхлээгүй байгаа зэргээс шалтгаалан маш бага байгаа юм. Үйл ажиллагааны явцад Оюутолгой хүнд даацын тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний ачаалал нь тээврийн хэрэгслийн угсралтын ажлаас хамааран үйл ажиллагааны 4 жилийн (2017) туршид өдөрт 160 тээврийн хэрэгсэл зорчдог болтлоо нэмэгдэх хандлагатай байна. Ингэснээр Оюу толгойн замын хөдөлгөөнөөс илүү ачаалалтай байгаа одоогийн нүүрс тээвэрлэж буй Оюу толгойн бус тээврийн хэрэгсэлд эсхүл оюу толгойн бус тээврийн хэрэгслийн ашиглаж байгаа замын байршилд Оюу толгой хяналт тавих боломж хязгаарлагдмал болох юм.

### **1.3 АНХНЫ ТӨЛӨВЛӨСӨН ЗАМЫН МАРШРУТАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ – ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ШИНЭЧЛЭН ӨӨРЧЛӨЛТ**

#### **1.3.1 Чиглэл өөрчлөгдсөн зам**

Оюу Толгой ХХК нүүрсний тээврийн машины замын хөдөлгөөний бөглөрөл, аюултай нөхцөл байдлаас тусдаа байдлаар төлөвлөсөн замыг сайжруулах ажил явж байх хугацаанд төслийн машины хил хүртэлх болон буцах аюулгүй ажиллагааг хангах зорилгоор түр зуурын чиглэл өөрчилсөн замыг (1-р зураг дээр Чиглэл өөрчлөгдсөн зам) Анхны төлөвлөсөн замын Цагаан Хадаас Хил хүртэлх замын хэсгийн оронд ашиглаж эхэлсэн.

ЭР-ын барьсан засмал замтай ойролцоо нэг эгнээ бүхий зам дээр Цагаан Хад болон Гашуун Сухайтын хооронд чиглэл өөрчлөгдсөн замыг засмал замыг барьж байх хугацаанд ашиглахаар барьсан. Энэ нэг эгнээ бүхий зам нь Говийн бага дархан цаазтай газрын (ГБДЦГ) завсрын бүс болон хязгаарлагдмал ашиглалтын бүсэд нэвтрэн орсон болно.

2011 оны 8-р сард Оюу Толгойн зам барилгын гэрээт гүйцэтгэгч (Алтайн Зам ХК) БОАЖЯ, ГБДЦГ-ын захиргаа болон Ханбогд сумын засаг даргад Оюу Толгойн төслийн талбайгаас Гашуун Сухайт

хүртэл замыг барих хугацаанд тээврийн хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх зорилгоор чиглэл өөрчлөгдсөн замыг ашиглах зөвшөөрөл авахыг хүссэн албан хүсэлт гаргасан билээ. 2011 оны 8-р сард БОАЖЯ, ГБДЦГ-ын захиргаанаас чиглэл өөрчилсөн замыг ашиглах талаар хүсэлтийг хүлээн авснаа баталж, мөн энэ сардаа БОАЖЯ болон ГБДЦГ-ын захиргааны зүгээс өмнө байсан замын оронд чиглэл өөрчилсөн замыг барьж, ашиглах, Оюу Толгойн төслийн талбайгаас Гашуун сухайт хүртлэх замыг засаж сайжруулсны дараа<sup>1</sup> энэ замыг нөхөн сэргээх нөхцөлтэйгээр зөвшөөрлийг олгосон билээ.

Зам дагуу байгаль орчны томоохон нөлөөлөл үүсэх эсэх болон хүрээлэн буй орон нутагт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй талаарх судалгааг Оюу Толгой ХХК-ийн Байгаль орчны хэлтсийн мэргэжилтнүүд хийсний дараа Оюу Толгой компаний Байгаль орчны хэлтсээс 2011 оны 11-р сарын 17-нд<sup>2</sup> газар хөндөх зөвшөөрлийг өгсөн.

Чиглэл өөрчилсөн замын ажил 2011 оны 11-р сарын 24-нд эхэлсэн бөгөөд өвлийн улирал болсонтой холбогдуулан 2011 оны 12-р сарын 15-нд зогссон бөгөөд улмаар 2012 оны 3-р сард дахин эхэлсэн. Чиглэл өөрчилсөн замын төгсгөл бүрд ЭР-ын төлбөртэй зам ашиглахаас зайлсхийсэн нүүрсний машинуудыг тус замыг ашиглахыг хязгаарлахыг зорилготой нүүрсний машинуудыг зогсоох хаалт, тэмдэглэгээ бүхий Оюу Толгой ХХК-ийн 24 цагийн хамгаалалтын постууд байна. Хамгаалалтын байр болон хаалтыг байрлуулсны дараа Чиглэл өөрчилсөн зам 2012 оны 4-р сарын 13-нд ашиглалтанд орсон.

Дараахь тээврийн хэрэгсэл Чиглэл өөрчилсөн замыг ашиглах зөвшөөрөлтэй болно. Үүнд:

- Оюу Толгой төслийн тээврийн машинууд;
- Оюу Толгой төслийн (замын) барилгын тээврийн хэрэгсэл ;
- Нийтийн тээвэр болон орон нутгийн жижиг, хөнгөн тээврийн хэрэгсэл;
- Цагдаагийн зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл.

Чиглэл өөрчилсөн замыг Анхны төлөвлөсөн замыг шинэчлэн сайжруулах ажил дуусах хүртэл ашиглана. Гэхдээ анхны төлөвлөсөн замыг шинэчлэн сайжруулах ажил эхлэхээс өмнө Засгийн газар болон нүүрсний компаниудын хооронд нүүрсний машинууд ЭР-ийн Хатуу хучилттай замаар заавал явуулах журмыг боловсруулж хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулах шаардлагатай. Мөн даацын хязгаарлалт болон замын төлбөрийн талаарх аливаа асуудлыг энэ гэрээнд тусгах шаардлагатай. Энэ тохиолдолд Оюу Толгой анхны төлөвлөсөн маршрутын замыг шинэчлэн сайжруулах ажлыг дуусгаж, чиглэл өөрчилсөн замд ашигласан газар нутгийг нөхөн сэргээх боломжтой болох юм.

### 1.3.2 Шинэчлэгдсэн маршрутын зам

Хилийн цэргийн удирдах газар анхны төлөвлөсөн маршрутын замыг цэргийн байгууламжид ойрхон барихыг зөвшөөрөхгүй байгаа бөгөөд цэргийн постоос хол зайтай байхаар тооцож энэ хэсгийг барих шаардлагатай. Энэ хэсгийг Шинэчлэгдсэн маршрутын зам гэж нэрлэн *1-р зураг дээр үзүүлсэн болно.*

Цэргийн байгууламжийн баруун талын уулархаг нутгаар дайрах гарах замын трассад өндөрлөг газрыг машин тээвэр, ачаа зөөх боломж бүхий нам дор газар болгон тэгшлэхийн тулд хөндөгдөөгүй газарт тэсэлгээ хийх шаардлагатай байгаа тул байгаль орчин, нийгэмд нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх боломж ихээхэн хязгаарлагдмал байгаа болно. Тиймээс цэргийн байгууламжийн зүүн талын замын трассыг сонгосон бөгөөд энэ трасс нь Говийн бага дархан цаазат газар 'Б' хэсгээр дамжин гарах болж байна. Энэ сонгон авсан трасс нь өмнө нь байсан замаар дамжиж байгаа бөгөөд Говийн бага дархан цаазат газраар дамжин гарах замын урт нь ойролцоогоор 3.1 км байна.

<sup>1</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Говийн бага дархан цаазтай газрын захирлын 2011 оны 8-р сарын 15-нд гарын үсэг зурсан болон Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2011 оны 11-р сарын 3-нд гарын үсэг зурсан албан захидал.

<sup>2</sup> Газар Хөндөх Зөвшөөрөл 111102. Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх чиглэл өөрчилсөн зам, 3-р Бүс . 2011 оны 11-р сарын 17.


2012 оны 2-р сард шинэчлэн өөрчлөх замын трассын дагуух соёлын өвийн байршил болон малчдын өвөлжөө, хаваржааны судалгааг хийсэн. Тус судалгаагаар өв уламжлалын гурван байршил (угсаатны зүйн хоёр байршил болон нэг булш) болон нэг малчны өвөлжөө болон худаг зэргийг хамруулсан. Оюу Толгой компаний ажилтан дээрх малчинтай 2012 оны 2-р сард холбогдож, замын маршрутыг шинэчлэх талаар мэдэгдсэн бөгөөд, малчин замын маршрутыг шинэчлэх ажлын талаарх мэдэгдлийг хүлээн авсан гэдгээ баталсан билээ. Оюу Толгой компани газар хөндөх зөвшөөрлийг 2012 оны 5-р сард өгсөн <sup>3</sup>.

Газар хөндөх зөвшөөрлийг өгснөөс хойш зам барих талбайн тэмдэглэгээг хийх (жижиг модон гадас ашиглан), шимт хөрсийг зарим газар шилжүүлэн байршуулах зэрэг зам барилгын бэлтгэл ажлыг хийж эхэлсэн. Говийн бага дархан цаазат газраас гадна карьер ухаж, түр замын цементийн үйлдвэрийг байгуулсан. Гэхдээ тээврийн асуудлыг шийдвэрлэх хүртэл энэ хоёр байгууламжийг ашиглахгүй байгаа билээ.

---

<sup>3</sup>Газар хөндөх зөвшөөрөл 120508. Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх чиглэл өөрчилсөн зам, 3-р бүс. 2012 оны 5-р сарын 25.

1-р Зураг: Замын Товчлон өөрчлөлт болон Дахин Өөрчлөлт



#### 1.4 ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨГДСӨН ЗАМЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Нүүрсний машинуудыг тусгаарлаж, зориулалтын замаар л явуулж байх тухай шийдвэр гарсан үед шинэчлэгдсэн замын маршрутын дагуу өөрчлөгдсөн анхны төлөвлөсөн замын маршрут барьж дуусгах юм. Оюу Толгой ХХК анхны төлөвлөсөн замыг барьж дуусгах зорилгоор нүүрсний хүнд даацын машинууд болон бусад замын хөдөлгөөний тусгаарлах талаар бусад талуудтай одоогоор зөвшилцөж байгаа бөгөөд анхны төлөвлөсөн замыг барьснаар Оюу Толгойн баяжмалыг хил рүү тээвэрлэх болон Хятадаас импортлогдсон бараа бүтээгдэхүүн тээвэрлэх хамгийн аюулгүй, үр дүнтэй зам болох юм. Оюу Толгой компани үйл ажиллагаанд ахиц дэвшлийн талаар зээл олгогчдод тогтмол мэдээлэл өгч байна.

Цагаан Хад болон хил хоорондын биологийн олон янз байдлын нарийвчилсан судалгааг нүүрсний хүнд даацын машинуудыг тусгаарлах асуудлыг шийдтэл хойшлуулсан болно. Энэ хугацаанд одоогийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй эсэхийг шалгах мөн аливаа боломжит биологийн олон янз байдлын сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор авах цаашдын нөлөөллийг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааг тодруулах зорилгоор хязгаарлагдмал биологийн олон янз байдлын үнэлгээг хийнэ.

Барилгын ажлын явцад гэрээт гүйцэтгэгчид, байгаль орчны үйл ажиллагааны үзүүлэлтийг Оюу Толгой компаний Байгаль Орчны хэлтсээс өгсөн Газар Хөндөх зөвшөөрлийн нөхцлийн дагуу зохион байгуулах болно. Тоосжилтыг хянан үр дүнтэй ажиллах талаар Газар Хөндөх зөвшөөрөлд тусгайлан дурдсан байдаг тул Гэрээт гүйцэтгэгч зам, карьерын тоос дарах төлөвлөгөөнд хэрхэн нийцэн ажиллаж байгаа талаар одоо хяналт шинжилгээ хийж байгаа болно.<sup>4</sup>

Шинэчлэгдсэн замын маршрутын дагуу өөрчлөгдсөн анхны төлөвлөсөн замын маршрутыг 2012 оны сүүлээр барьж дуусгах төлөвлөгөөтэй байна. (Одоогийн байдлаар энэ замын зарим хэсгийг 2013 онд барьж дуусгах арга хуваарьтай байна). Оюу Толгой нь Цагаан Хад болон Гашуун Сухайтын хооронд анхны төлөвлөсөн замын маршрутыг аюулгүй нөхцөл байдалд барих зорилгоор хаах тохиолдолд дараахь үр дагавар учирна. Үүнд:

- Нүүрсний хүнд даацын машинууд чиглэл өөрчилсөн замаар явах магадлалтай; энэ нь Оюу Толгой компаний зүгээс аюулгүй байдлын хүлээн зөвшөөрч болохооргүй эрсдлийг бий болгох бөгөөд чиглэл өөрчилсөн замын нөхцөл байдал улам бүр муудахад хүргэх; буюу
- Нүүрсний хүнд даацын машинууд ЭР-ын Хатуу хучилттай замыг ашиглахгүйгээр хил рүү явах өөрсдийн замыг гаргах; үүнийг Оюу Толгой компани байгаль орчин болон орон нутгийн хувьд хүлээн зөвшөөрч болохгүй эрсдлийг бий болгоно гэж үзэж байна (ялангуяа бүс нутгийн биологийн олон янз байдалд).

Дээрх хоёр үр дагаварын ноцтой эрсдлийг тооцон үзсэний үндсэн дээр Оюу Толгой компани анхны төлөвлөсөн замын маршрутын энэ хэсгийг хаахаар шийдсэн бөгөөд эцсийн шийдлийг Оюу Толгой болон нүүрсний компаниуд, холбогдох төрийн байгууллагатай одоо үргэлжлэн явагдаж байгаа хэлцлийн үр дүнд олох юм.

#### 1.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГМИЙН АСУУДЛУУД

Чиглэл өөрчилсөн зам болон шинэчлэгдсэн замын маршрутууд нь Оюу Толгой төслийн Нөлөөллийн бүс буюу шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд байгаа болно.<sup>5</sup> Оюу Толгой төсөлд хамаарах амьдрах орчны шалгуур үзүүлэлт, цар хүрээг тодорхойлох зорилгоор Оюу Толгой

<sup>4</sup>Оюу Толгойн Газар Хөндөх зөвшөөрөл – 120508. 2012 оны 5-р сарын 25.

<sup>5</sup>Оюу Толгой төсөл, БОННУ. А Хэсэг, Бүлэг А1 Танилцуулга. 2012.



уурхайн БОННБҮ-ий хүрээний суурь судалгааны хүрээнд 'ЧУХАЛ' амьдрах орчны үнэлгээг хийсэн болно.<sup>6</sup> Оюу Толгой төслийн хоёр нэгж шинжилгээнд үнэлгээ хийсэн болно. Үүнд:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо сумд болон Говийн Бага Дархан газрын А болон Б хэсгийг хамруулсан томоохон хэмжээний дүн шинжилгээний томоохон нэгж (51,415 км<sup>2</sup>) (өргөн хүрээтэй/томоохон хөхтөн амьтдад экологийн хувьд тохирохуйц хэмээн тогтоогдсон);
- Ханбогд, Манлай сумдыг хамруулсан жижиг хэмжээний дүн шинжилгээний нэгж (27,375км<sup>2</sup>) (уурхай болон үүнд хамааралтай дэд бүтцийн боломжит нөлөөлөл, тэр дундаа хоёр сумыг хамарсан гидрологийн боломжит нөлөөлөл үүдэн гарч болох учраас бүх төрөл зүйлс, төрөл зүйлсийн бөөгнөрөл, хувьсалын үйл явц болон экосистемийн үйлчилгээ экологийн хувьд тохирохуйц хэмээн тодорхойлогдсон).
- ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт 6, Бүлэг 9, Оюу Толгой төслийн Чухал амьдрах орчны зааварчилгаа болон ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага 6, Бүлэг 13-т тодорхойлогдсон шалгуурууд дээр тулгуурлан дээр дурдсан дүн шинжилгээний хоёр нэгж нь чухал амьдрах орчин гэж тодорхойлогдсон юм: Үүнд:
- Дүн шинжилгээний томоохон нэгжийн дийлэнх хэсэг нь Зэрэглэл 1-т багтах хулангийн амьдрах чухал орчин;
- Дүн шинжилгээний томоохон нэгж тэр чигээрээ Зэрэглэл 2-т багтах аргаль болон хар сүүлт зээрийн амьдрах чухал орчин. Дүн шинжилгээний жижиг хэмжээний нэгж тэр чигээрээ Зэрэглэл 2-т багтах чухал амьдрах орчин болох Монгол буурцгана, Могойч загалай, ургамалын бүлгийн боржины илрэл, экосистемийн 4 үйлчилгээ, тухайлбал усны зохицуулалт, мал (мөн бэлчээр), биотүлш болон цэвэр ус бүхий амьдрах орчин.

2006 оны 7-р сард Монголын Шинжлэх Ухааны Академийн (МШУА) Археологийн Хүрээлэн Анхны Төлөвлөсөн Замын маршрутын тээврийн зурвас бүсэд археологийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Шинэ Чулуун Зэвсгийн үед хамаарах хэлтэрхий, чулуун багаж хэрэгсэл зэрэг эд өлгийн зүйлсийг олсон бөгөөд чулуун зэвсгүүдийг хоорондоо нэлээн зайтай олсон буюу ямар нэгэн суурин газар энд байхгүй байсныг харуулж байна. Дундад зууны үед (13-14-р зуун) хамаарах паалан гадаргатай шаазан ваарны хэсэг бас олдсон. Товчхондоо тээврийн зурвас бүсэд ямар нэгэн томоохон археологийн олдвор, эд өлгийн зүйл байхгүй бөгөөд цаашдын эрэл хайгуулын ажил хийх шаардлагагүй гэж үзсэн.

## 1.6 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Чиглэл өөрчилсөн зам болон шинэчлэгдсэн замын маршрутын үнэлгээ нь хязгаарлагдмал мэдээлэл болон өмнө нь тодорхойгүй байсан боломжит нөлөөлөл зэргээс шалтгаалан нэмэлт тодотгол хийсэн уурхайн БОННБҮ-ий суурь мэдээлэлд тулгуурлах болно.

Судалгааны хүрээ нь асуудал тус бүр дэхь боломжит холбогдох нөлөөллийн бүсүүдтэй холбогдоно.

Анхны төлөвлөсөн замын маршрут болон 220 Кв-ын цахилгааны шугамыг оролцуулсан дэд бүтцийн зурвас бүсийн байгаль орчны судалгааг 2004 болон 2006 онуудад Уурхайн БОННБҮ-ий хүрээнд хийсэн бөгөөд Оюу Толгойн БОННБҮ-ий<sup>7</sup> үндсэн тайланд орсон болно. Дээр нь, Оюу Толгой компанийн мэргэжилтнүүд 2011 оны 9 болон 11-р саруудад Газар хөндөх зөвшөөрлийг өгөхөөс өмнөх шалгалтыг Чиглэл өөрчилсөн замын маршрутын бүс нутагт хийсэн бөгөөд холбогдох Газар хөндөх зөвшөөрлийг өгөхөөс өмнөх үзлэг шалгалтыг шинэчлэгдсэн замын маршрутад 2012 оны 4-р сард мөн хийсэн.

Чиглэл өөрчилсөн зам болон шинэчлэгдсэн замын маршрутын бүс нутагт дараахь нэмэлт судалгааг хийхийг санал болгож байна. Үүнд:

<sup>6</sup>ТВС & FFI (2011) Оюу Толгой төслийн чухал амьдрах орчны үнэлгээ: ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 6 / Олон улсын биологийн төрөл зүйлийн олон янз байдал, Ургамал болон Амьтдын аймгийн зөвлөх байгууллагын нийтлэгдээгүй тайлан, 2011 оны 12 дугаар сар.

<sup>7</sup>Оюу Толгой төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Бүлэг I, Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэл зам болон дэд бүтцийн зурвасын тайлан, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө, Эко-Трейд ХХК, 2004; Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэл зам болон дэд бүтцийн зурвасын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодруулга, 2006 он

- **Биологийн олон янз байдал болон Экосистемийн үйлчлэл** – замын ойролцоо байгаа бүсийн амьдрах орчны шууд болон шууд бусаар алдагдах, том биетэй амьтад зам хөндлөн гарах үедээ машин тэрэгтэй мөргөлдөх эрсдэл, зам сайжруулж засварлах үед Оюу Толгойн төслийн талбайгаас Гашуун Сухайтын замаас машин техникийг холдуулах зорилготой түр арга хэмжээ болох чиглэл өөрчилсөн замыг ашиглахын тулд Говийн Бага Дархан Цаазат газар руу нэвтрэн орох, бүс нутгийн хөрс болон геологи, байгаль орчны хүртээмж багасаж, муудах, ялангуяа бүс нутагт байгаа малчдын хувьд хамааралтай ;
- **Ажиллах хүч болон ажлын нөхцөл** – Оюу Толгойн ажлын нөхцөл болон гэрээт гүйцэтгэгчийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (ЭМААБО) шаардлагыг дагаж мөрдөх, ажилчдын байр орон сууцны стандарт болон холбогдох зөвшөөрлийн нөхцлийг дагаж мөрдөх;
- **Соёлын өв** – замын маршрутын ойролцоох соёлын өвийн байршлуудад нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- **Бохирдлоос урьдчилан сэргийлэх болон нөөц боломжийг зөв зохистой, үр дүнтэй ашиглах** - барилгын ажлын явцад гэрээт гүйцэтгэгч компаниас гарсан хог хаягдлын зөв зохистой менежментийг хийх, хог хаягдлын хяналт болон усны эх үүсвэр болон хэрэглээ;
- **Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал** – замын аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх, Цагаан Хадын хүн амын шилжилт хөдөлгөөний менежмент, онцгой байдлын үеийн зогсох шаардлага болон амрах үед замын хажуугийн байгууламжийг ашиглах;
- **Газар чөлөөлөлт** – Замын үйлчилгээ болон засвар үйлчилгээний бүсэд зориулж газрыг авч нөөцлөх, ялангуяа, Говийн Бага Дархан Цаазат газрын бүсийн газрыг авах, нөөцлөхтэй холбогдуулан гарч болзошгүй асуудлыг Говийн Бага Дархан Цаазат газрын захиргаатай ярьж шийднэ. Хэдийгээр эдийн засгийн хувьд нөлөөлөлд өртөлтийн хамгийн бага нөлөөлөлтэй байна гэж үзэж байгаа ч чиглэл өөрчилсөн зам болон шинэчлэгдсэн замын маршрутын малчдад үзүүлэх нөлөөллийг авч үзнэ.

Дээр нь, аливаа асуудлын талаарх оролцогч талуудын үзэл бодлыг, ялангуяа Говийн Бага Дархан Цаазат газар доторх замын байршил, ойлгох үүднээс хэлэлцэх үйл явцыг авч хэрэгжүүлнэ.

## 1.7 ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын<sup>8</sup> талаар Гүйцэтгэлийн стандарт болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банкны (ЕСБХБ) Байгаль орчин болон Нийгмийн бодлогын<sup>9</sup> Гүйцэтгэлийн шаардлагын дагуу Шинэчлэгдсэн зам болон чиглэл өөрчилсөн замын маршрутын үнэлгээг хийнэ. Ялангуяа, Олон Улсын Санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандартуудыг авч үзнэ. Үүнд:

- Гүйцэтгэлийн стандарт 1 - Байгаль Орчин, Нийгмийн Эрсдлийн болон Нөлөөлөлийн Үнэлгээ болон Менежмент;
- Гүйцэтгэлийн стандарт 2- Ажиллах хүч болон Ажлын нөхцөл (ОУСК/ЕСБХБ-ын Ажилчдын Орон Сууцны талаархи Зааварчилгаа);
- Гүйцэтгэлийн стандарт 3 – Нөөц боломжийг зөв зохистой, үр дүнтэй ашиглах болон бохирдлоос урьдчилан сэргийлэх;
- Гүйцэтгэлийн стандарт 4 – Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн стандарт 5 – Газар чөлөөлт болон албадан нүүлгэн шилжүүлэх;
- Гүйцэтгэлийн стандарт 6 – Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалалт болон амьд нөөц баялгийн тогтвортой менежмент;

<sup>8</sup>Олон Улсын Санхүүгийн Корпораци. Байгаль Орчин, Нийгмийн Тогтвортой байдлын Гүйцэтгэлийн Стандарт. 2012 оны 1-р сарын 1-ээс хүчинтэй. Олон Улсын Санхүүгийн Корпораци, Дэлхийн Банкны Групп.

<sup>9</sup>Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк. Байгаль орчин, нийгмийн бодлого. 2008 оны 5-р сар.

- Гүйцэтгэлийн стандарт 8 – Соёлын Өв.

ЕСБХБ-ын дараахь стандартууд үнэлгээнд ихээхэн хамааралтай. Үүнд:

- Гүйцэтгэлийн шаардлага 1 – Байгаль Орчин, Нийгмийн Үнэлгээ болон Менежмент;
- Гүйцэтгэлийн шаардлага 2 – Ажиллах хүч болон Ажлын нөхцөл (ОУСК/ЕСБХБ-ын Ажилчдын Орон Сууцны талаар Заавар)
- Гүйцэтгэлийн шаардлага 3 – Бохирдлоос урьдчилан сэргийлэх болон бууруулах;
- Гүйцэтгэлийн шаардлага 4 – Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн шаардлага 5 – Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн шилжүүлэх болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт;
- Гүйцэтгэлийн шаардлага 6 – Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалалт болон Байгалийн нөөцийн тогтвортой менежмент;
- Гүйцэтгэлийн шаардлага 8 – Соёлын өв;
- Гүйцэтгэлийн шаардлага 10 – Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох болон оролцогч талуудыг татан оролцуулах.

Мөн ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамжийг үнэлгээнд ашиглана. (2007).

Шинэчлэсэн зам болон чиглэл өөрчилсөн замын маршрутын байршлыг тогтооход Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль. (1997) болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995) зэрэг Монгол улсын холбогдох хууль тогтоомжоор тавигдах шаардлагыг дагаж мөрдөнө.

## 1.8 ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үнэлгээгээр чиглэл өөрчилсөн зам болон шинэчлэгдсэн замын бүсэд голлон анхаарах бөгөөд одоо байгаа суурь мэдээлэл болон нэмэлт судалгааг Уурхайн БОННБУ-ий цогц Нэмэлт Үнэлгээ болгон нэгтгэнэ. Үүнд Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон ОУСК болон ЕСБХБ-ын байгаль орчин, нийгмийн стандартын дагуу тавигдах шаардлагын хүрээнд боломжит нөлөөллийг багасгах, зохистой хэмжээнд менежмент хийхэд шаардлагатай нэмэлт менежментийн болон нөлөөллийг бууруулах арга хэмжээ бас орно.

Говийн Бага Дархан Цаазат Газрын доторх замын хөдөлгөөний асуудлыг урт удаан хугацаанд шийдвэрлэх талаар тус үнэлгээгээр авч үзэхгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн Газар, Оюу Толгой ХХК болон Энержи Ресурс компанийн хоорондын зөвшилцлийн үр дүнд тодорхой болно. Урт удаан хугацааны шийдэл шаардлагатай болох үед энэ нь эцсийн байдлаарх загварчлалд Оюу Толгойн оруулах сонирхолтой байгаа байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзан үзсэн тохиромжтой түвшний байгаль орчин, нийгмийн үнэлгээгээс хамаарах юм.

Үнэлгээний үр дүнг Оюу Толгой төслийн Үйлдвэрлэлийн шатны биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнд тусгах бөгөөд биологийн олон янз байдлын нөлөөллийн үнэлгээг шаардлагатай бол Төслийн эерэг нөлөөлөлд ахиу үзүүлэх бүртгэл тооцоо, дүйцүүлэн хамгаалах менежментийн стратеги болон төлөвлөгөөг шинэчлэхэд ашиглана. Мөн Төслийн Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын эрсдэл болон нөлөөллийн дасан зохицох менежментийн аргачлалд тусган авч хэрэгжүүлнэ.

## 1.9 ҮНЭЛГЭЭНИЙ ХИЙХ ХУГАЦАА

2012 оны 12-р сард Оюу Толгой компаниас олон нийтэд нээлттэй болгох нэмэлт үнэлгээнд оруулах ба заагдсан хуваарьт багтаах үүднээс энэ судалгааг одоо хийж байгаа болно.